



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/217/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. Аудитын илрүүлэлт .....	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	21-22

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН РАШААНТ  
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.БҮРЭНЦОГТ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/217/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь бидний тогтоосон 14,855.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1, 2021 оны 237 дугаар тогтоолын 1, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар тушаалын 1, БШУС-ын 2023 оны А/386 дугаар тушаалын 1.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Шууд худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааг нийтэд нээлттэй зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй,
- Хичээлийн жил эхлээгүй 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэл хөлс олгосон,
- Илүү цаг ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажил, цагийн тооцоогүйгээр илүү цагийн нэмэгдэл цалин олгосон,
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй,
- Үдийн хоолны нормативт зардлыг хэтрүүлсэн,
- Сургалтын менежерт долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр нэмэгдэл цалин хөлс олгосон,
- Сургуулийн нягтлан бодогчийн ажлын байрыг тус суманд байнгын оршин суугч бус хүнээр гүйцэтгүүлж буйгаас хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг тасралтгүй гүйцэтгүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бөгөөд анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зөрчил материаллаг байдлаар оршиж байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 33,283.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 9 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106,536,721.33	143,485,360.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,520,726.42	67,021,775.57
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	62,520,726.42	67,021,775.57
3121	Төгрөг	62,520,726.42	67,021,775.57
31211	Төрийн сангийн харилцах	62,520,726.42	67,021,775.57
33	АВЛАГА	1,864,392.01	1,864,392.01
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,000.00	50,000.00
335	Бусад авлага	1,814,392.01	1,814,392.01
3351	Байгууллагаас авах авлага	1,348,000.01	1,348,000.01
3352	Хувь хүмүүсээс авах авлага	466,392.00	466,392.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,151,602.90	74,599,193.00
351	Түүхий эд материал	112,120.00	112,120.00
3513	Эм боох материал	112,120.00	112,120.00
354	Хангамжийн материал	42,039,482.90	74,487,073.00
3541	Бичиг хэргийн материал	7,612,956.84	10,342,386.94
3542	Аж ахуйн материал	29,360,246.06	61,922,246.06
3546	Хүнсний материал	4,796,840.00	1,953,000.00
3547	Бусад хангамжийн материал	269,440.00	269,440.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	950,956,662.55	928,102,005.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	950,956,662.55	928,102,005.85
392	Биет хөрөнгө	888,984,262.47	866,129,605.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	904,329,874.00	904,329,874.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(148,125,042.73)	(178,950,400.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,885,775.68)	(15,485,775.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,108,415.50	148,783,960.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,034,657.03)	(68,790,149.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,732,744.40	77,788,354.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,698,022.86)	(36,787,467.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,506,217.64	7,506,217.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,000,000.00)	
39217	Ном	11,050,509.23	11,734,992.63
393	Биет бус хөрөнгө	61,972,400.08	61,972,400.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,499,999.92)	(1,500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,972,400.00	61,972,400.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,057,493,383.88	1,071,587,366.43
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,281,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		16,281,000.00
413	Өглөг		16,281,000.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		16,281,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,057,493,383.88	1,055,306,366.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,057,493,383.88	1,055,306,366.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,443,955.60	275,443,955.60
51101	Өмч: - төрийн	213,471,555.60	213,471,555.60
512	Хуримтлагдсан үр дүн	8,521,223.67	6,334,206.22
5121	Өмнөх үеийн үр дүн	8,521,223.67	8,521,223.67
5122	Тайлант үеийн үр дүн		(2,187,017.45)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	773,528,204.61	773,528,204.61
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,057,493,383.88	1,071,587,366.43

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,025,660,435.37	1,367,807,638.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,796,828.80	43,897,138.50
120	Нийтлэг татварын бус орлого	44,796,828.80	43,897,138.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,793,500.00	785,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		785,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,793,500.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	35,142,088.50	40,382,608.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,861,240.30	2,729,430.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	980,863,606.57	1,323,910,499.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	843,071,500.00	1,188,843,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	843,071,500.00	1,188,843,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,497,648.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,497,648.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,294,458.57	135,067,299.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,294,458.57	135,067,299.94
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	990,341,330.71	1,369,994,655.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,341,330.71	1,369,994,655.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	955,097,289.21	1,308,812,915.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	644,092,396.00	934,692,898.00
210101	Үндсэн цалин	456,930,487.00	605,815,382.00
210102	Нэмэгдэл	169,848,373.00	298,244,216.00
210104	Урамшуулал	17,313,536.00	30,633,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,888,596.77	115,408,839.51
210201	Тэтгэврийн даатгал	56,153,656.77	78,771,018.88
210202	Тэтгэмжийн даатгал	6,574,698.05	9,434,581.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,198,158.23	4,654,809.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,268,713.88	4,502,636.43
210205	Эрүүл мэндийн даатгал	12,693,369.84	18,045,793.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,402,578.57	135,067,299.94
210301	Гэрэл, цахилгаан	7,178,738.01	7,384,299.94
210302	Түлш, халаалт	114,319,520.00	122,879,440.00
210303	Цэвэр, бохир ус	9,904,320.56	4,803,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,713,480.00	
210604	Урсгал засвар	4,713,480.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,351,499.06	13,536,107.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,793,500.00	785,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,557,999.06	12,751,007.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,648,738.81	110,107,770.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,731,069.00	33,791,921.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,777,000.00	9,469,964.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,140,669.81	66,845,885.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,244,041.50	61,181,740.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,244,041.50	61,181,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,244,041.50	39,547,640.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,634,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	35,319,104.66	(2,187,017.45)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,319,104.66	(2,187,017.45)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	982,657,106.57	1,324,695,599.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,793,500.00	785,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,793,500.00	785,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,793,500.00	785,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		785,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,793,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	980,863,606.57	1,323,910,499.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	843,071,500.00	1,188,843,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	843,071,500.00	1,188,843,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,497,648.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,497,648.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,294,458.57	135,067,299.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,294,458.57	135,067,299.94
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	930,846,120.90	1,316,585,930.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,846,120.90	1,316,585,930.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	894,068,739.40	1,258,248,030.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	644,092,396.00	934,692,898.00
210101	Үндсэн цалин	456,930,487.00	605,942,682.00
210102	Нэмэгдэл	169,848,373.00	298,116,916.00
210104	Урамшуулал	17,313,536.00	30,633,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,888,596.77	115,634,099.51
210201	Тэтгэврийн даатгал	56,153,656.77	78,996,278.88
210202	Тэтгэмжийн даатгал	6,574,698.05	9,434,581.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,198,158.23	4,654,809.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,268,713.88	4,502,636.43
210205	Эрүүл мэндийн даатгал	12,693,369.84	18,045,793.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,402,578.57	135,067,299.94
210301	Гэрэл, цахилгаан	7,178,738.01	7,384,299.94
210302	Түлш, халаалт	114,319,520.00	122,879,440.00
210303	Цэвэр, бохир ус	9,904,320.56	4,803,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,891,880.00	
210604	Урсгал засвар	4,891,880.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,351,499.06	13,536,107.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,793,500.00	785,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,557,999.06	12,751,007.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,441,789.00	59,317,625.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,524,789.00	49,847,661.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,917,000.00	9,469,964.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,777,381.50	58,337,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,777,381.50	58,337,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,777,381.50	36,703,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,634,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,810,985.67	8,109,669.15
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,765,100.00	3,608,620.00
	Дотоод эх үүсвэрээр	23,765,100.00	3,608,620.00
222001	Тоног төхөөрөмж	23,513,700.00	2,233,000.00
223001	Бусад хөрөнгө	251,400.00	1,375,620.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(23,765,100.00)	(3,608,620.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,045,885.67	4,501,049.15
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		62,520,726.42
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		67,021,775.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	8,521,223.67	1,057,493,383.88
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			(2,187,017.45)	(2,187,017.45)
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	6,334,206.22	1,055,306,366.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,444,688,500.00	1,320,194,550.79	124,493,949.21	91.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,444,688,500.00	1,320,194,550.79	124,493,949.21	91.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,386,350,600.00	1,261,856,650.79	124,493,949.21	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	979,040,900.00	934,692,898.00	44,348,002.00	95.5
210101	Үндсэн цалин	612,512,800.00	605,942,682.00	6,570,118.00	98.9
210102	Нэмэгдэл	335,879,700.00	298,116,916.00	37,762,784.00	88.8
210104	Урамшуулал	30,648,400.00	30,633,300.00	15,100.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,380,100.00	115,634,099.51	6,746,000.49	94.5
210201	Тэтгэврийн даатгал	83,218,500.00	78,996,278.88	4,222,221.12	94.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,790,400.00	9,434,581.87	355,818.13	96.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,895,200.00	4,654,809.23	240,390.77	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,895,200.00	4,502,636.43	392,563.57	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,580,800.00	18,045,793.10	1,535,006.90	92.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,541,300.00	135,067,299.94	47,474,000.06	74.0
210301	Гэрэл, цахилгаан	7,587,600.00	7,384,299.94	203,300.06	97.3
210302	Түлш, халаалт	155,213,300.00	122,879,440.00	32,333,860.00	79.2
210303	Цэвэр, бохир ус	19,740,400.00	4,803,560.00	14,936,840.00	24.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,626,700.00	15,076,107.84	7,550,592.16	66.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	785,100.00	785,100.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,841,600.00	14,291,007.84	7,550,592.16	65.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,761,600.00	61,386,245.50	18,375,354.50	77.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,776,600.00	51,787,281.00	17,989,319.00	74.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,985,000.00	9,598,964.50	386,035.50	96.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,337,900.00	58,337,900.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,337,900.00	58,337,900.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,703,800.00	36,703,800.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,634,100.00	21,634,100.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,444,688,500.00	1,324,695,599.94	119,992,900.06	91.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,251,362,100.00	1,188,843,200.00	62,518,900.00	95.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,188,843,200.00	1,188,843,200.00	-	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	62,518,900.00		62,518,900.00	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	182,541,300.00	135,067,299.94	47,474,000.06	
132001	Орон нутгийн төсвөөс	182,541,300.00	135,067,299.94	47,474,000.06	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,785,100.00	785,100.00	10,000,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	785,100.00	785,100.00	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00			
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		62,520,726.42	(62,520,726.42)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		67,021,775.57	(67,021,775.57)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн сурах, хөгжих арга барилыг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зөв цэвэр тэмдэглэх чадварт суралцуулах, хөгжүүлэх,
- Бие даан сурах арга барилыг төлөвлөн эзэмшүүлэх,
- Өглөөний уншлагаар дамжуулан уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэх,
- Эрүүл зөв дадал хэвшүүлэх,
- Бие биенийхээ ялгаатай байдлыг ойлгох хүндэтгэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*  
*Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,094.0 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	62,520.7	67,021.8	4,501.1
Авлага	1,864.4	1,864.4	-
Бараа материал	42,151.6	74,599.2	32,447.6
Үндсэн хөрөнгө	950,956.7	928,102.0	(22,854.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,057,493.4</b>	<b>1,071,587.4</b>	<b>14,094.0</b>
Өр төлбөр	-	16,281.0	16,281.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,057,493.4	1,055,306.4	(2,187.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,057,493.4</b>	<b>1,071,587.4</b>	<b>14,094.0</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 67,021.8 мянган төгрөг болж 4,501.1 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 74,599.2 мянган төгрөг болж 32,447.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 105,522.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 2,729.4 мянган төгрөгийн сурах бичиг үнэ төлбөргүйгээр авч, үйл ажиллагаанд 75,803.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 928,102.0 мянган төгрөг болж 22,854.7 мянган төгрөгөөр буурсан нь Боловсролын ерөнхий газраас 3,608.6 мянган төгрөгийн давхар ор, сурагч ширээ сандал, таблет, аймгийн Боловсролын газраас 20,670.8 мянган төгрөгийн сурах бичиг, зөөврийн компьютер, ухаалаг зурагт, Бат боловсролын үр ХХК-аас хандиваар 2,310.0 мянган төгрөгийн сургалтын ширээ, сандал, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер үнэ төлбөргүйгээр тус тус хүлээн авч, тайлант онд 66,845.9 мянган төгрөгийн элэгдэл тооцоноос шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 16,281.0 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамны ерөнхий гэрээний дагуу Персон хөтөлбөрийн хүрээнд лизингийн гэрээгээр нийлүүлэгдсэн цахим ангийн хэрэглэгдэхүүний үлдэгдэл төлбөрөөс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 841,936.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 182,541.3 мянган төгрөг нийт 1,024,478.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 420,210.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,262,147.2 мянган төгрөгөөр, нийт 1,444,688.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,408,103.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 182,541.3 мянган төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 10,785.1 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 62,518.9 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,444,688.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 350,399.5 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 24,004.7 мянган төгрөгөөр,

- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 22,626.7 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 23,179.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,262,147.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 182,541.3 мянган төгрөг, нийт **1,444,688.5** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,320,194.5 мянган төгрөгийг зарцуулж, 67,021.7 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,320,194.5 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх зардлыг 5,791.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 47,474.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 56,171.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>1,262,147.2</b>	<b>1,185,127.2</b>	<b>67,021.7</b>	<b>93.9</b>
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,496.7	2,473.5	23.2	99.1
80233 - Хүүхэд хамгаалал	2,559.4	2,559.4	-	100.0
80312 - Сургалт семинар	2,024.7	985.2	1,039.5	48.7
81605 - Эрүүл мэндийг дэмжих	3,769.5	3,660.0	109.5	97.1
81801 - Үдийн цай хөтөлбөр	36,703.9	36,703.8	0.1	100.0
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,413.1	16,281.0	132.1	99.2
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	7,491.0	1,700.0	5,791.0	22.7
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,110,881.2	1,054,709.9	56,171.3	94.9
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	66,050.9	63,826.0	2,224.9	96.6
81848-Сурах бичгийн түрээс	785.1	785.1	-	100.0
81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	2,972.8	1,443.3	1,529.5	48.6
83603- Дээд шатны төсвөөс	10,000.6	10,000.0	0.6	-
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>182,541.3</b>	<b>135,067.3</b>	<b>47,474.0</b>	<b>100.0</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	182,541.3	135,067.3	47,474.0	74.0
<b>ДҮН</b>	<b>1,444,688.5</b>	<b>1,320,194.5</b>	<b>114,495.7</b>	<b>91.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 36,703.8 мянган төгрөгийн үдийн цайны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Улаанбаатар төмөр зам” ХНН, Замбалзоог ХХК, иргэн Наранчимэг нартай тухай бүр гэрээ байгуулж худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмжийг өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 990,341.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,855.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 166 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 2 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 2 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт – 1 удаа,

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудагд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Улаанбаатар төмөр зам” ХНН, Замбалзоог ХХК, иргэн Наранчимэг нартай шууд гэрээ байгуулж үдийн цайны хүнсний материалын худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/50 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,980.5 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 66.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	1	1,282.6	1	1,282.6	100.0
Албан шаардлага	1	558.1	1	558.1	100.0
Зөвлөмж	2	6,139.8	2	6,139.8	50.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>7,980.5</b>	<b>4</b>	<b>7,980.5</b>	<b>66.6</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **24,276.6** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд 5,142.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 2,853.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал дутуу тайлагнагдсан,
- Боловсролын ерөнхий газраас 2 жилийн хугацаагаар лизингээр нийлүүлэгдэж буй утасгүй интернэтийн сүлжээний тоног төхөөрөмжийн 16,281.0 мянган төгрөгийг хөрөнгөөр бүртгэлгүй шууд зардлаар тайлагнасан, үлдэгдлийг өр төлбөр үүсгэн бүртгээгүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.3: “бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Аудитаар нийт **32,492.6** мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрч 2 төлбөрийн акт, 4 албан шаардлага хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэлд 152.7 мянган төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай” тушаалын 1 дэх “Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон анги даалтын нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Илүү цаг ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажил, цагийн тооцоогүйгээр нягтлан бодогч Л.Мөнхбатад илүү цагийн цалинд 1,704.1 мянган төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх *"Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, ...ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ"*. 3.2: *"Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, .....ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## **5.2 Албан шаардлага**

1. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийн бараа, ажил үйлчилгээний зардлаас томилолтын зардалд 476.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Үдийн цай хөтөлбөрийн зарцуулалтын тооцоог хянаагүйгээс нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативт зардлыг хэтрүүлж, нийт 1,966.6 мянган төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар *"Үдийн хоолны норматив тогтоох тухай"* тогтоолын 1 дэх *"Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үдийн хоолны нормативыг мөрдөн, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерт долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 1,971.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, БШУС-ын 2023 оны А/386 дугаар тушаалын 1.1 дэх “Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Сургуулийн нягтлан бодогчийн ажлын байрыг тус суманд байнгын оршин суугч бус хүнээр гүйцэтгүүлж буйгаас хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг тасралтгүй гүйцэтгүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бөгөөд гэрээ, төсөв, нэхэмжлэх, цахим төлбөрийн болон бараа материалын орлого, зарлагын баримтгүй, албан тушаалтны гарын үсгээр баталгаажаагүй, үдийн хоолны хүүхдийн ирцийг үнэн зөв бүртгээгүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар 26,221.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7. дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогчийн ажлын байрыг нийтэд зарлаж, уг ажлын байрыг тасралтгүй гүйцэтгүүлэх замаар хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө дутуу тайлагнагдсан	2	7,995.6	2	7,995.6			2	7,995.6				
Өр төлбөр тусгалгүй орхигдуулсан	1	16,281.0	1	16,281.0			1	16,281.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>24,276.6</b>	<b>3</b>	<b>24,276.6</b>			<b>3</b>	<b>24,276.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анги даалтын нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	152.7	1	152.7								
Нотлох баримтгүйгээр илүү цагийн хөлс бодож олгосон.	1	1,704.1	1	1,704.1								
Зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.	1	476.0			1	476.0						
Үдийн цайны зардлын нормативыг хэтрүүлсэн.	1	1,966.6			1	1,966.6						
Сургалтын менежерийн хичээл заах цагийг хэтрүүлсэн	1	1,971.6			1	1,971.6						
Анхан шатны баримт бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	26,221.6			1	26,221.6						
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>32,492.6</b>	<b>2</b>	<b>1,856.8</b>	<b>4</b>	<b>30,635.8</b>						

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Үдийн цайны хүнсний худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	36,703.8			1	36,703.8		
Дүн	1	36,703.8			1	36,703.8		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>36,703.8</b>			<b>1</b>	<b>36,703.8</b>	<b>1</b>	<b>-</b>